

“ФЕОДАЛИЗМ” БА “ФЕОДАЛИЗМЫН ЭРСЭГ” ОЙЛГОЛТЫН ТУХАЙ

Д.Энхцэцэг доктор Ph.D) МУИС-ийн Түүхийн тэнхим

И.Саруул (доктор Ph.D) МУИС-ийн Нийгэм соёлын антропологийн тэнхим

Түлхүүр үг: Дундад зуун (medium ovum), “Феодализм” (feudalism), “Феодализм” ойлголтын эсрэг, “эзэн харьяатын ёсон”

Өгүүллийн товч: Дундад зууны үе (medium ovum) -ийн монголын түүхийн улс төрийн харилцааны асуудал “эзэн харьяатын ёс”-той нягт холбоотой байдаг болохоор дэлхийн түүхэн дэх “феодализм”, “феодализмын эсрэг” ойлголтын талаар болон монголын түүхэнд феодализм байсан уу?, нүүдэлчдийн нийгмийн хөгжлийн нийтлэг болон өвөрмөц онцлогийн талаар зарим нэг асуудлыг энэ өгүүлэлдээ хөндсөн болно.

XIV зууны эцсээс XVIII зуун хүртэл 300 гаруй жил үргэлжилсэн засаглалын хямрал, улс төрийн үйл явцтай холбоотой тус орны эдийн засаг, улс төр, нийгмийн зохион байгуулалтын бүхэл, нэгдмэл бүтэц задарч, нийгэмд “хувь эзэшилд” тулгуурласан саланги тусгаар бие даасан том жижиг эзэмшлүүд бий болсон. Өөр өөрийн хувь эзэмшил бүхий ноёд, сурвалжтаны бие даасан байдал нэмэгдэн, улс төр-эдийн засгийн хувьд бэхжихийн хирээр, ээн хааны засаглалын төвлөрсөн удирдлагын хүчийг сулруулж, хүч нөлөө нь доройтсон хааныг дагахаасаа эс дагах нь дийлэнх болон тэмцэл, задрал, бутралыг бий болгосон нь Монгол төрийн оршин тогтнох үйл явцад нөлөөлж, хөгжил дэвшил, үндэсний аюулгүй байдалд ч сөргөөр нөлөөлөх болж, улс орны төр засаг, төрийн бодлогын нэгдмэл цул байдаг, эвдрэл, хямрал өөр зуурын тэмцэл, эрх мэдэл газар нутаг, худалдааны зам харгуй, албат иргэд, дайны олз ашгаа булаадах тэмцлээр солигджээ.

Түүхийн шинжлэх ухааны онол-арга зүйн шинэ хандлага, ялангуяа монголын нийгэм-улс төрийн түүхийн судалгааны хүрээнд, “Засаглалын легитим хямрал”, “мөргөлдөөн”, “улс төрийн зөвшилцөл” зэрэг улс төрийн шинжлэх ухааны категориудаас улбаалан XIV –XVII зууны Монголын улс төрийн түүхийн олон асуудлыг задлан шинжлэх нь нэн чухал юм. Түүхийн судалгаанд энэ үеийн үндсэн агуулгыг “**нийгмийн задрал**”, “**иргэншлийн задрал**”, “**Деинтеграц (Disintegrate)**” “**феодалын бутрал**”, “**улс төрийн бутрал**” гэсэн олон янзын ойлголтоор илэрхийлж, хэдийгээр нийгмийн зөрчил илрэх нь улс төрийн амьдралд илүүтэй ч, үүний шалтгаан эрт үеэс улбаатай, нийгэм түүхийн үйл явцаар нөлөөлдөг, эерэг сөрөг нөлөөллийг улируулан судлах хандлага уламжилж ирсэн. А.Тойнби “...Нийгмийн бие мах бодийн доторхи гүнээс үүсдэг хагарал зөрчил нь уг асуудлыг ойлгох түлхүүр юм, учир нь иргэншлийн эвдрэл буснилын гол хэмжүүр, үндсэн шалтгаан нь нийгэм өөрөө тохинон тохирох чанараа алдахад хүргэж буй *дотоод тэсрэлт* юм. Энэ тэсрэлтийн ул мөр болох нийгмийн ан цав нь бусниж эхэлсэн нийгмийн бие махбодид год харагддаг. *Нутаг дэвсгэрийн хувьд тусгаар салангид нэгдлүүдийн хооронд* “Босоо”, ялгал гарсан бол харин ангиудад хуваагдсан холимог нэгдлүүдийн хооронд “хөндлөн” ан цав гарч... “Босоо” ан цав гарахад нийгэм ...хэд хэдэн улс болж хуваагдаж, цус асгарулсан өвөр хоорондын дайн гарах үндэс болдог. Ийм дайн тэмцэлдэгч хоёр талын альнэг нь эсрэг этгээдээ хиар цохиж, өөрийн засаглал, хатуу дэг журам тогтоохгүй бол нийгмийг туйлдуулдаг...Дэлхийн түүхэнд...иргэншлийн эвдрэл буснилын 16 тохиолдлын 14 нь өвөр хоорондын дайныг шатлан өргөжүүлсэн явдал гол шалтгаан болжээ. Нийгэм орон нутгийн шинжтэй хэсэг нэгдэл болон задрах явдал ямарч хэв маягийн нийгэмд нийтлэг үзэгдэл”¹ болохыг судалжээ.

Түүнчлэн “орчныг хянах нийгмийн чадвар, иргэншлийн эвдрэл, задралын үйл явцын хооронд хатуу нарийн дүйцэл байхгүйг эмпирик судалгаа харуулсан. Тиймэрхүү

¹ А.Тойнби.Түүх судлал. УБ.,2007, тал. 253-254

холбоо байдаг ахул орчныг эрхшээлдээ оруулах гэсэн оролдлого даамжрах тусам өсөх биш эвдрэх, задрах үйл явц эхэлдэг байж болохыг гэрчлэх баримтууд байдаг”² болно. Нийгмийн задрал “сарнил бутрал” (*Деинтеграц-Disintegrate*) нь, “палингенез”(Regeneration)³ (дотоод сэргэлт) гэсэн процессийг⁴ дагуулдаг гэж үзжээ. Хэдийгээр зөрчил мөргөлдөөн үүсч задрал будрал, эвдрэл сүйрлийг авчрах ч түүнийг зогсоох, даван туулах, сэргийлэх зорилгоор авч буй оролдлого, арга хэмжээний үрээр нийгэмд уламжлалт болон шинэ, шинэ зүйл бий болж байдаг.

Нүүдэлчдийн уламжлалт нийгэм дэх “нэгдэл – задрах – нэгдэл”-ийн түүхийг тусгайлан судалсан нь ховор ч, хүн төрөлхтөний түүхэн хөгжлийн жам ёсны үзэгдэл байсан нь мэдээж, олон мянган жилийн түүхийн явцад задрах – нэгдэх – задрах ...тасралтгүй гинжин хэлхээ мөнх үргэлжилжээ. Задрах, нэгдэх үйл явц бүхэн тухайн цаг үеийн нийгэм – түүхийн онцлог, тухайн ард түмний өвөрмөц шинжээр нөхцөлддэг. Дундад зууны үе (*medium ovum*)⁵ бол эртний соёл иргэншлийн суурин дээр нийгэм – эдийн засаг, соёлын илүү өндөр шат болох нийгэм үүсч, хөгжиж, унасан үе гэж түүхийн шинжлэх ухаанд үздэг болохоор дундад зууны үеийн монголын түүхийн улс төрийн харилцааны асуудал “эзэн харьяатын ёсон”-той нягт холбоотой байдаг.

“Феодализм” (feudalism) гэдэг үг, XVIII зууны үед өнгөрөөсөн, үтэр түргэн арилж буй тогтолцоог нэрлэж анх гарчээ. Бурангуй ёс, хууль дүрэм, ёс заншлыг нэрлэх сөрөг утгатай байжээ. XVIII зууны үеийн Франц, Английн хуульчид язгууртнуудын хоорондын уламжлалт үүрэг хариуцлагыг тайлбарлах үүднээс анх хэрэглэсэн бол 1748 онд Монтескью “Хуулиудын амин сүнс” зохиолд дурдсанаар олноо ихэд түгжээ.⁶ Түүнээс хойш хүмүүс янз бүрээр ойлгож, хэрэглэсээр ирсэн. XVIII зуунд соён гэгээрүүлэгчид “феодализм”-ыг Францын хаант засаг хуучин дэглэм хуучирсныг шүүмжлэх зорилгоор хэрэглэв. Сэргэн мандалтын үед дундад зууныг “харанхуй эрин, бүдүүлэг хаад”, феодализмыг ч тохуурхан бичиж⁷ хаант засгийн муу муухайг дэлгэн харуулж улс төрийн бодлогодоо ашиглаж байв.

Сонгодог утгаар авч үзвэл феодальн нийгмийн харилцаа нь газар лугаа холбоотой. Феодализмыг “Эзэд, хамжлага ард, газар гурав” хамтдаа байж сая бүрдүүлнэ. “Эзэн нь газар өмчилсөн язгууртан. Эзний газрыг гэрээ болзлоор эзэмшсэн хүн бол “fief” гэнэ. Газар өгсний хариуд хамжлага ард цэргийн хүч үзүүлнэ. Эзэн, ард, газар гурвын харилцаа, эрх үүрэг хариуцлага феодализмын суурийг бүрдүүлнэ гэж тодорхойлдог. Эзэн газраа олгохдоо “эзэндээ морь нохой мэт үнэнч” (fidelitas) өөрийн хамжлагыг бий болгон эзэн, харьяат хоёр бие биендээ үүрэг хариуцлага хүлээлгэсэн феодальн харилцаанд шилжин ордог байна. Эзний үндсэн үүрэг газрыг хамжлагад түрээслүүлж газраа эд баялгаа, харц ардыг ч гадны халдлагаас хамгаалах үүрэг хүлээнэ. Харцын үндсэн үүрэг эзэнд “тус” үзүүлэх буюу цэргийн хүч өгөх, ургацаас тодорхой хувийг эзэндээ өргөнө, өөр бусад үүргүүд ч бий... Хаан бол язгууртнуудад газар олгож харьяатаа болгоно, язгууртнууд нь хамжлага ардад газар олгож албатаа болгох шат дамжлагаар хаан нь “бүхнийг” өөрийн харьяанд оруулан, “төгс хаант засаглал” -ын суурь тавигдаж дэлхий дахинд дэг журам тогтдог гэж Өрнө дахины түүхэнд тэмдэглэсэн байдаг. *Karl Marx* феодализмын талаар Францын хувьсгалчид лугаа бараг ижил байр суурь баримтлан, “язгууртнууд цэргийн хүчээр тариалангийн талбайг эзэмшиж, эзэн

² А.Тойнби. Түүх судлал. УБ.,2007, тал. 253

³ Палингенезия –Дахин төрөхүй, Regeneration – дотоод сэргэлт

⁴ А.Тойнби. Түүх судлал.УБ.,2007, тал. 255

⁵ Энэ нэр томъёо XV зууны үед Европын гуманистуудын дунд анх үүсчээ.Эртний Грег, Ромын үед хүн төрөлхтөний соёл иргэншил цэцэглэн хөгжиж байснаа V зууны үед уналтанд орж, тэд өөрсдийнхөө үед дахин сэргэсэн гэж үзээд V-XV зууны хоорондох үеийг “Дундад зуун” хэмээн нэрлэж, эхэндээ Европын түүхнээ хожим дэлхийн түүхэнд хэрэглэх болсон.

⁶ de Secondat, Charles, Baron de Montesquieu. The Spirit of the Laws. 2 vols. Originally published anonymously. 1748; Crowder, Wark, and Payne, 1777. Spirit of Laws. Online posting. constitution.org. Trans. Thomas Nugent (1750). Rev. J. V. Prichard. ("Based on a public domain edition published in 1914 by G. Bell & Sons, Ltd., London.

⁷ Jean le Rond d'Alembert (1717–1783) Encyclopédie. Pierre Bayle (1647–1706) Nouvelles de la république des lettres and Dictionnaire historique et critique. G.L. Buffon (1707–1788) L'Histoire Naturelle Baron d'Holbach (1723–1789) The System of Nature. Denis Diderot (1713–1784) Encyclopédie

харъяатын ёс дагуу тариачдыг мөлжсөн нийгмийн давхарга төлөвшүүлдэг"⁸ гэж “Философийн гуйланчлал” (1847) зохиолдоо феодализмыг дан ганц эдийн засгийн загварын үүднээс тайлбарласан байдаг.

Марксист болон марксист бус аль ч сэтгэлгээнд “феодализм” (feudalism) хэмээх ойлголт өгөн хэрэглэгддэг ч агуулгын хувьд нилээд ялгаатай тэмдэглэгдэж иржээ. Марксистийн үүднээс “феодализм бол боол эзэмших байгууллыг халан гарч ирсэн нийгэм эдийн засгийн байгуулал, хүн төрөлхтний түүхэн хөгжлийн гарцаагүй зүй тогтолт шат мөн” гэж үздэг бол Өрнөдийн философи, социологи, түүхийн шинжлэх ухаанд-феодализм бол лорд (сеньор) нар, вассал (түшээ) захирагдсандаа газар өмчлүүлж ивээл, хамгаалал үзүүлж, хариуд нь тэд эзэндээ үнэнчээр үйлчилдэг байдалд үндэслэдэг Баруун Европын төрт ёсны систем хэмээн тайлбарладаг бөгөөд “феодализм бол дэлхий нийтийн түгээмэл, зүй тогтолт нийгмийн байгуулал” гэсэн үзэл илэрдэггүй байна.

Сүүлийн 150 жилийн туршид судлаачид феодализмыг тойрон мэтгэлцсээр байна. Марксист эдийн засагч *Paul Sweezy*, Британийн эрдэмтэн *Maurice Dobb*⁹ нар бие биенээ үгүйсгэж иржээ. *John Horace Round*¹⁰, *Frederik William Maitland*¹¹ нарын маргаан эдүгээ ч үргэлжилсээр байна. Түүхч *Francois-Lois Ganshof* “феодализмыг хууль, цэргийн ойлголтын хүрээн дотроо орших, зөвхөн дундад зууны язгууртны явцуу хүрээнд гарч ирнэ”, “Эзэн газраа хамжлагдтүрээслэн, ард өөрийн цэргийн хүчийг эзэндээ өргөнө”¹² гэх феодализмын талаарх сонгодог үзлийг “Феодализм” (1944) зохиолдоо бичжээ. Францын түүхч *Mark Bloch* феодализмыг цэрэг, хууль зүйн талаас нь бус, социологийн талаас судалж, “Феодал нийгэм” (1939) бүтээлдээ “Феодализм бол дан ганц язгууртны хүрээний нийгэм бус” ноёд, тариачдын хооронд ихил төсөөтэй үүрэг хариуцлагууд байгаа ажиглагдаж, “Феодал ёсны харилцаанд тариачид эрх тэгш оролцоно” гэх радикал тайлбар хийн газрын хариуд цэргийн хүч өгч, ивээл хамгаалалтын хариуд биеийн хүчээ үнэлүүлнэ, хоёул феодалын харилцаанд хамаарна гээд фесдаг (ёсонд) нийгмийн бусад элемент бий бөгөөд амьдралын бүхий л зүйлс “эзэн ноён”- ийг тойрон эргэлдэж, сүмийн тогтолцоо, феодалын ялдам уран зохиол, феодалын эдийн засгийг үүгээр тайлбарлаж чадна”¹³ гэж үзэж байв.

Тэгвэл “Феодализм” ойлголтын эсрэг АНУ-ын түүхч *Elizabeth Brown* “Онолын харгислаг: феодализм, дундад зууны Европын түүхчид” (1974) зохиолдоо “феодализм” үгийг хэрэглэх нь нэгдсэн ойлголтонд хүргэж чадахгүй, буруу тийш хөтлөөд байна гэж өмнөх ойлголтуудыг няцаагаад, феодализм бол дундад зууны бодит зүйл бус, харин орчин үеийн түүхчид түүхэн баримтаас “хүчээр” ургуулан гаргасан гэж үзжээ. Дундад зууны түүхийн ном зохиолуудаас энэхүү ойлголтыг “бүрмөсөн арилгана”¹⁴ гэж. Брауныг дэмжигчид шаардав. “Газар, харцас дундад зууны үйл явдлыг эргэн сурвалжлахуй” (1994) зохиолдоо *Susan Reynolds* Брауны онолыг улам баяжуулжээ. Тэрээр Дундад зууны Европынх лугаа төстэй боловч Өрнөдийн бус нийгмүүдэд “феодал” гэх ойлголтыг ашиглах нь ихэвчлэн тохиромжгүй. “Феодализм” гэх ойлголтыг олон янзаар хэрэглэсний улмаас түүний гол мөхлөг ала болж, нийгмийг тайлбарлах зөв ойлголт болж чадахаа больжээ”¹⁵ гэж үздэг байв.

⁸ The Poverty of Philosophy, by Karl Marx, Progress Publishers, 1955; First Published: in Paris and Brussels, 1847

⁹ Sweezy, Paul M., et al. The transition from feudalism to capitalism (NLB, 1976). Maurice Herbert Dobb Political Economy and Capitalism: Some essays in economic tradition, 1937

¹⁰ John Horace Round. Feudal England (1895)

¹¹ Frederik William Maitland History of English Law before the Time of Edward I (with Sir Frederick Pollock, 1895; revised 1898;)

¹² Ganshof, Francois-Lois, Feudalism. Tr. Philip Grierson. New York: Harper and Row, 1964.

¹³ Bloch, Marc, Feudal Society. Tr. L.A. Manyon. Two volumes. Chicago: University of Chicago Press, 1961

¹⁴ Brown, Elizabeth, 'The Tyranny of a Construct: Feudalism and Historians of Medieval Europe', American Historical Review, 79 (1974), pp. 1063-8.

¹⁵ Reynolds, Susan, Fiefs and Vassals: The Medieval Evidence Reinterpreted. Oxford: Oxford University Press, 1994

Феодализмын түүхийн хувьд, Европ дахь феодализмын анхны хэлбэрүүд эртний Ром, Германаас уламжлалтай, дэлхийн олон оронд харилцан адилгүй түүхэн нөхцөл, цаг хугацаанд феодалзм бүрэлдэн тогтож, үеэ өнгөрөөсөн, хөгжлийн түвшин нь ч өөр байжээ. Энэ үеийг огт дайраагүй ард түмэн Америк, Африк, Австралид бий. Феодализмын мөхлийн талаар авч үзвэл, цаг улирах тусам газрын эзэд харьяат хүмүүстээ шинэ газар олгож чадахаа больж, де факто өв залгамжлалын хуулиар өөрсдийн эрхээ баталгаажуулж, феодализм хөдөлмөрийн харилцаанд тулгуурлах нь алдагдан, эдийн засгийн хөдөө аж ахуйн ихэнх тогтолцоо таваарын харилцаанд татагдан орж, газар үндэстэй феодализм бөхөхөд хүргэв. Газар өмчлөл нь дөмөг орлоготой, нийгэмд нэр хүндтэй хэвээр байсан ч язгууртнууд улам ихийг олж эзэмших, булаан дээрэмдэх сонирхолтой болж улам бүр хүчирхэгжив. Энэ хэлбэрийг ихэвчлэн “дээрмийн феодализм” гэдэг юм. Ноёд дотоодын асуудлаа өөрсдөө шийдвэрлээд, хаанаас хамаарах нь багассаар, бие даасан язгууртнуудын байр суурь бэхжиж ирэв. Хаад ноёдын зөрчил тэмцэл энэ үеийн гол агуулга болж, түүхч **Ж.Ж.Бэгли** “XV зуунд жинхэнэ феодализм үеэ өнгөрөөж, XVI зуунд хаант засаг, бүрэн эрхт улс, улсуудын хоорондын дайн гарах хөрс суурь тавигджээ. XVI зуунд феодализм бодит амьдралаас тасарч бүдгэрэв. Хүмүүс ч анзаарахаа больж, хэрэгцээ шаардлага үгүй болжээ” гэж феодализмын задрал, мөхлийн талаар өөрийн үзэл бодлоо дэвшүүлсээр иржээ.

Монголын түүхэнд феодализм байсан уу? Нүүдэлчдийн нийгмийн хөгжлийн нийтлэг болон өвөрмөц талыг судлах, дэлхийн түүхэн үйл явцад ямар байр суурь эзэлдэг болох зэрэг олон асуудал байдаг. Суурин феодализмын мөн чанарыг газар хэний эзэмшилд, өмчинд байгаагаар тайлбарладаг бол “монголд газар, мал хоёрын харилцан шүтэлцэээр тайлбарлах онол давамгайлсан **“нүүдлийн феодализм”** хэмээх өвөрмөц нэр томъёо 1930-аад оны үед Оросын судлаачид хэрэглэх болж...нүүдэлчдийн нийгмийн үүслийг хүй нэгдэлтэй болбон тайлбарлах...нүүдэлчдийн өөрийн төр ёс, улс гүрэн байгуулж байсангүй...”¹⁶ гэх үзэл ноёрхож байв. Энэ үеэс Зөвлөлтийн онолчид¹⁷ “түүхийн марксист диалектикаас нүүдэллэхгүйг төдийгүй, нүүдлийн феодализмын онолыг бий болгожээ” гэж үздэг. 1950-иад оноос тоталитар дарангуйлал зөөлрөх хандлагатай болж, нийгмийн ухаанд үзүүлэх үзэл суртлын дарамт суларчээ. Оросын ихэнх судлаачид нүүдлийн феодализмын онолыг шүүмжлэх болж, нүүдэлчдийн түүхийн судалгаанд шинэ арга зам хайж, уламжлалт бус шийдэл эрэлхийлэх болсон. “...Азийн нүүдэлчдийн формац оршин тогтнож байсан тухай (А.М.Хазанов, Коган, Марков, Н.Крадин)¹⁸, нүүдэлч малчдын нийгмийн хөгжлийн онцгой зам байсан гэдгийг үндэслэх оролдлогууд”¹⁹ хамгийн их маргаан дагуулж байжээ. Марков “олны танил (феодализмыг) тэс ондоо зарчим, онцгоос авч үзсэн...(нь)” эл онолыг үндэслэл баримттай унагаан, А.М. Хазанов: “...Нүүдэлчид бие даасан хувьслын хүрээнд эртний төрт ёсны бүрдэлд хүрэх боломжтой”²⁰, “нүүдэлчдийн нийгэм...гадаад суурьшсан ертөнцөөс ихээхэн хамааралтай” гэж үзэх явдал эдүгээ хүртэл баримтлах болсон.

Монголын нийгэм, судалгаанд “феодализм”, “феодалын бутрал” гэх томъёолол 1950-иад оны үеэс²¹ анх нэвтрэн түүхийн сэтгэлгээнд феодализмын тухай марксист ойлголтыг баримталж, хүн төрөлхтөн бүхэлдээ энэ нийгмийг “гарцаагүй туулдаг зүй тогтолтой” хэмээн нотлох үндсийг баримталж, нийгэм түүхийн олон асуудлыг тайлбарласаар ирсэн. Академич Ш.Нацагдорж монголын феодализмын түүхийг бүхэлд нь улируулан судалсан нэгэн сэдэвт зохиолдоо монгол орны нийгэм эдийн засаг, улс төр засаг захиргааны түүхийг өргөн хүрээнд авч үзэн, “нүүдэлчдийн нийгмийн хөгжийн

¹⁶ Н.Крадин. “Эрнест Геллнер ба нүүдлийн феодализмын талаархи мэтгэлцээн” МУИС. Түүх. сэтгүүл-III. УБ., 2004, тал. 49-58

¹⁷ Б.Владимирцов, С.Толстой, Н.Кузьмин нарын бүтээлүүд

¹⁸ Н.Крадин. Эрнест “Геллнер ба нүүдлийн феодализмын талаархи мэтгэлцээн” МУИС. Түүх сэтгүүл-III. УБ., 2004, тал. 49-58

¹⁹ Мөн тэнд

²⁰ Н.Крадин. “Эрнест Геллнер ба нүүдлийн феодализмын талаархи мэтгэлцээн” МУИС. Түүх сэтгүүл-III. УБ., 2004, тал. 49-58

²¹ БНМАУ-ын түүх. УБ., 1954, Ш.Нацагдорж. Монголын феодализмын үндсэн замнал. УБ., 1978, тал. 15, 35

нийтлэг ба онцлогийг”²² судалж нүүдэлчдийн нийгмийн амьдралд байгалын хүчин зүйлүүдийн²³ нөлөөлөл багагүй байдгийг анхаарахын зэрэгцээ нийгмийн харилцааны үндэс нь “феодалын газрын өмч”, “малыг хувьдаа өмчлөх”-ийн диалектик нэгдэл, харилца холбоог харгалзан үзэх “нүүдлийн мал аж ахуйн нөхцөлд газар, мал хоёр нийлээд үйлдвэрлэлийн гол хэрэгсэл болж”²⁴ феодализм хэрхэн үүсч, тэрлэж хэрхэн үеэ өнгөрөөсөн болон, монголын феодализмын задралын асуудлыг шинээр авч үзэн, феодализмын өөрийн зүй тогтлын дагуу “задралд хүргэдэг” болохыг судалжээ.

Өнөөдөр монголын түүхийн судалгаанд хэвшмэл ойлголтыг өөрчлөх “түүх ба нийгмийн сэтгэлгээнд буй зохистой зүйлийг мэдэрч...эх түүхээ дахин үнэлэн цэгнэх замаар юдитой дүгнэлт хийх” боломж бүрдсэнээр “нийгэм, түүхийн” зохиомол тайлбар бий болохоос зайлсхийх болсон. Өрнөдийнхний сэтгэлгээнд “феодализм бол дэлхий нийтийг түгээмэл зүй тогтолт нийгмийн байгуулал гэсэн үзэл илэрдэггүй” гэх үзлийг анхаарах болсон. XIII-XX зууны 20-иод он хүртэлх нийгмийн байгууллыг “феодализм” гэж ойлгох, эсэх талаар эргэн харахыг оролдож байна. Энд “феодализм”, зарим нь “эзэн харъяатын ёс”, “монголын уламжлалт нийгэм”, “Азийн үйлдвэрлэлийн арга”²⁵, “билчээийн газар эзэмшлийн хамжлагат нийгэм”, “нүүдэллэхүй ёсон (nomadism)”, “шилжилт хөдөлгөөнтэй билчээрийн мал аж ахуй (mobile)”²⁶ гэж нэрлэж, нэгдсэн ойлголт өнөө хүртэл үгүй байна. Зарим судлаачид Баруун Европ болон Монголын уламжлалт нийгмийг түүхийн жишилтийн аргаар ижил төсөөтэй ба ялгаатай талыг тодорхойлохыг оролдож, эдийн засгийн үндэс, нийгэм улс төрийн байгуулал, нийгмийн бүтэц, оюун санааны амьдралын онцлогын хувьд...ялгаатай бөгөөд ижил зүйл байгаа ч”...баруун Европын феодализмын системийг бүрэлдүүлэгч гол гол элементүүд Монголын уламжлалт нийгэмд байгаа нь XIII зуунаас хойшхи Монголын нийгмийг феодализмд хамааруулах талтай”²⁷ “феодализм” хэмээн үзэх хангалтай үндэслэл өгөхгүй байгаа юм. Монголын эдийн засаг, нийгэм, төрийн зохион байгуулалт, аж төрөх ёс маяг, оюуны амьдралын дүр төрх Европоос үлэмж ялгаатай “Монголын уламжлалт нийгмийг феодализмд хамааруулах нь...түүхэн замналыг Дундад зууны Европын түүхийн загвар лугаа адилтгах байдалд оруулж ирсэнийг засах”²⁷ шаардлагатай гэж үзэх болжээ. Хэдийгээр феодализмын талаар ялгаатай ойлголтууд гарсаар байгаа ч өнөөгийн түвшинд Ш.Нацагдоржийн бүтээлүүдээс өөр бүхлд нь тайлбарлан, тусгайлан нягтлан судалсан судалгаа хараахан үгүй байна. Нэр томъёоны хувьд харилцан ялгаатай ойлголтуудыг эс тооцвол *агуулгын хувьд өнгөрсөн зууны днд үеэс эдүгээ хүртэлхи Монголын дундад үеийн судалгаанд адил төсөөтэй зүйлс олон, нөгөө талаар Монголчуудын түүх, хүн төрөлхтний түүхээс огт өөр замаар амнадаггүй болох нь тодорхой юм.*

Европынхны ойлгодог феодализмтай зэрэгцүүлбэл нүүдэлчдийн байгал цаг уур, эрхлэх аж ахуй, аж төрөх ёсноос улбаасан хамжлагат ёс сул байсан нь монголын феодализм өвөрмөц шинж болохоос “феодализм” эсвэл “хамжлагат ёс”, “эзэн харъяатын ёс” байгаагүй гэж үзэх аргагүй. Эртний Дорно дахины орнуудад газар улсын өмч байсан, монголд ч бас тийм. Энэ талаарх Монголын эзэн харъяатын ёс (феодализм) бусад орныхтой нийтлэг гэж үздэг нь нийгмийн хөгжлийн эхэн үед адилхан бөгөөд энэ нийтлэг талыг нилээд судалсан юм. Харин онцлог зүйлүүдийг судлах явдал учир дутагдалтай хэвээр л байна. Энэ онцлог нүүдэлчдийн уламжлалт нийгмийн хөгжлийн түүх болно. Нүүдлийн мал аж ахуйн нөхцөлд билчээр нутаг “нийтийн баялаг” гэх боловч түүнийг булаалдан ноёд язгууртнууд нь, эгэл нүүдэлчид нь ч газар миний эдэлгээнд байх учиртай гэсэн ойлголтоор газарт хувийн өмч мэт хандаж ирсэн талтай. Гэвч, нөгөө талаар түүхийн

²² Ш.Нацагдорж. Монголын феодализмын үндсэн замнал. УБ.,1978, тал. 18

²³ Мөн тэд, тал. 26

²⁴ Мөн тэд, тал. 33

²⁵ Маркс.Л, Энгельс.Ф. Соч. 2 изд. т.13. с.7

²⁶ Кэроли Хамфри. Дэвид Снит. Нүүдэллэхүй ёсон эцэслэх үү?. УБ.,2006

²⁷ Ц.Гомбсүрэн. “Монголын уламжлалт нийгэм феодализм мөн үү?” УБ.,1997

туршид монголд газрыг хаад, ноёд харьяат иргэд албатуудаа эрхшээл захиргаандаа байлгах хүчирхэг хэрэгсэл, иргэдэд зөвхөн үйлдвэрлэл эрхлэл аж ахуй хөтлөх нөхцөл болгон ашиглаж байв.

Нүүдэлчдийн нийгэмд газрыг эзэгнэх гээд байдгийн гол учир нь “хүмүүсийн нэг хэсэг, нөгөө хэсгийнхээ амьдралын гол хэрэгслэлийг булааж, эрхшээлдээ оруулах”²⁸ зорилготой байсан. Газар нутаг овог аймгийн дундын өмч байхаа больж, түүнийг булаалдан өмчлөх гэсэн язгууртан, сурвалжтан, хан нарын явуулсан тэмцэл дайн самуун бие биеэ халж солисоор, олон хаант улсын түүхийн гол агуулга болсоор ирсэн ч тэдгээрийн хэн нь ч газрыг өмчилж чадалгүй, эзэн хааны буюу улсын өмч болгож, тэд өөрсдөө зөвхөн хувь хишиг газрыг эзэмшигчид байсаар ирсэн. Монголд овгийн язгууртан, аймаг угсаатны тэргүүн нар хатуу зөөлөн, цустай цусгүй арга замаар юуны урьд “хүн олныг мал, хөрөнгө хогшил, үйлдвэрлэн бүтээдэг зүйлтэй нь улмаар газар нутагтай нь хамт эрх мэдэлдээ оруулахдаа хүн, мал үгүй газар нутагт өнгөлзөж байгаагүй бололтой. Ийм эзгүй нутаг хангалттай их байв. Эзэн ноён нэгэнт хүмүүсийг харьяалж байгаа болохоор тэдний нутаглан нүүдэллэн байдаг газар нутгийг эзэмших нь зүй ёсны хэрэг юм. Хүчтэй нь хүчгүйгээ илт дарлах, дур зоргоор ноёлох харилцааг дээдлэн, түүнээ олох хэлбэрийг алба татвараар хэрэгжүүлж байсан нь газар гэхээсээ засаглал тэдний өмч болчихоод байсных ажээ”. Хүний ажиллах хүч таваар болж өмчлөлийн объект болдогтой адил засаглах эрх бас өмчлөлийн объект болж зохицуулах чиг үүрэг шийдвэрүүд нь татвар авах хүчин зүйл болох үндэстэй юм.

Чингис хаан түмэт, мянгат, зуут, аравтаар зохион байгуулагдсан цэрэг иргэнийг сурвалж язгууртан, цэргийн жанжин нарт хуваарилахдаа газар нутгийг нь “дайвар” болгон олгосон. “Монголд газар хааных учраас түүн дээрхи бүх хүн хааны албат, зарц боол мэт байв”²⁹. Монголын феодализмд шууд үйлдвэрлэгчдийг газарт бэхлэх ёс нь түүнийг “эзэнд нь хадаж өгөх, цэрэг засаг захиргааны нэгжид багтаан оруулах хэлбэрээр гүйцэлдэж, биеийн харьяалал чухал үүрэгтэй байв”³⁰ гэх мэт тэмдэглэснээс үзвэл Монголын феодализмын харилцаа үүсэл, бэхжин, тогтох урт удаан хугацааны үйл явцад “хүн-эзэмшил”, “газар-эзэмшил” хоёрын аль нь анхдагч болох вэ? гэвэл юуны өмнө “хүн эзэмшил, газар эзэмшил” чухал байсан бол феодалын харилцаа задрах үеэс “газар эзэмшил” тэргүүлэх чиглэлтэй болсон³¹. Нийгмийн хөгжлийн тодорхой шатанд Монголын феодалууд харьяат албатаа бусдад өгөх (худалдах) бэлэглэх, шагнах эрхтэй байсан, хожим нь албат хамжлага ардууд эзэн дээдэс ноёдын эзэмшлийн объект болж, зөвхөн үүгээр дамжин ард олон газар нутагт бэхлэгдэж, феодалууд газрын дээд өмчлөгчдийн (улсын) эрх ашгийг хохироохгүйгээр өөртөө алба татвар (гувчуур) гаргуулан газрыг ч харьяат нараа ч хагас өмчлөх эрхтэй байв. Дорно, өрнийн орнуудад “газар-эзэмшил” тэргүүлэх болсноор үй олон хүн, газраас хөөгдөн, хот суурин, гар урлал, аж үйлдвэр, барилгад шилжих болж, феодализмын өөрийгөө халах үндсийг бий болгосон байна.

Нүүдэлчин монголчуудын хувьд өрх, аж ахуйтныг газар билчээргүй болгох, хөөн зайлуулах, мал сүргийг нь хурааж авах боломж нөхцөл байгаагүй. Ус билчээрийн хүрэлцээ даацаас шалтгаалан ихэнх өрх аж ахуйн хэмжээ нийтдээ жижиг, баян аж ахуй тооны хувьд цөөн, сул чөлөөт ядуучууд бас л цөөн байв. Монголд газар нутгийг эзэмших “өмчлөх” нь газар, мал хоёрыг дагаж гарч ирээгүй, харин “харь овог”, “хувь улс”, “хувь аймаг”-аа дагаж ирсэн үзэгдэл буюу түрэмгийлэн булаах засаглалыг дагаж ирсэн үзэгдэл мөн. Юуны өмнө “хүнийг эзэмших”, “сонирхол” харц иргэн эзэн ноёнгүй аваас яахин явмой” ёсыг бий болгон тал нутгийн язгууртнууд хүнийг угсаа залгамжлан эзэмших

²⁸ Монголын нийгмийн харилцаан дахь газрын харилцааны асуудлаас. (Монголын хувь заяаны тулгамдсан асуудлууд. Цуврал 1.) УБ., 1997, тал.14

²⁹ Н.Ишжамц. Монголд нэгдсэн төр улс байгуулагдаж, феодализм бүрэлдэн тогтсон нь. УБ., 1974, тал. 78, 88

³⁰ Ш.Нацагдорж. Монголын феодализмын үндсэн замнал. УБ., 1978, тал.64

³¹ Монголын нийгмийн харилцаан дахь газрын харилцааны асуудлаас. (Монголын хувь заяаны тулгамдсан асуудлууд. Цуврал 1) УБ., 1997, тал.15

болсон. Хүмүүсийг газарт шууд аргамжих боломж монголын нийгэмд байгаагүй учраас хувийн малтай байлгаж билчээр нутагтай нь холбон, “булаан хэрэглэх”-аян дайны хэрэгслэлээр оролцогсодод оногдох олзоор аргамжих арга ч бас нэг онцлог юм. Хүч хамтран булаалцаж, өөрийн болгох, дахин хуваарилах хувь эзэмшил шинээр бий болох үйл явц тасралтгүй үргэлжлэх нь нүүдэлчдийн эдийн засаг, нийгэм, улс төрийн хэрэгцээ шаардлагатай холбоотой олон зууны турш оршиж байв. XIII зуунд нэгдмэл хүчирхэг төр улс байгуулан газар нутгийг өмчлөгч нь хаан байж, түүний харьяатээд ноёдын шууд өмчийн хэсэг газар бий болж ашиглалт, нүүдэл суудлыг зохицуулж, харьяат нарын дунд ашиглалтын нийтийн газар нутгийг заан өгч билчээр нутгийг өөрөө мэдэн сонгож, малаа өсгөн эзэндээ татвараа төлж байх, харьяат нарыг бас малтай байлгаж татвараа авч байх гэсэн эзэд ноёдын сонирхлыг бодит зүйл болгон, дотоодын зөрчил тэмцэл зогсчээ. Хүн, мал бүхий газар өмчлөл нь нүүдэлчдийн дунд эзэн харьяатын харилцаа бэхжин тогтох, төгөлдөржихөд шийдвэрлэх ач холбогдолтой зүйл болсон. **Хүнтэй, малтай, баялагтай нь** байгалаас заяагдсан газрыг булаалдан, авч улс гэрээ төвхнүүлэх тулаанд (тэмцэлд) ялан дийлсэнээр “эзэгнэн захирах” хангалуун хэрэглэх хүслээ онцгой эрх сүр, хүчээр хэрэгжүүлж чадсаны гэрч юм.

Хүн ард, мал хөрөнгө, эд баялгийг газар нутагтай нь өөрийн захиргаанд оруулсан Чингис хааны үед улсын газар нутгийг академич Ш.Нацагдорж³² “Эзэн хааны өмч...мянганы нутаг, хааны ургийн гишүүдэд хишиг болгон өгсөн харьяат газар нутаг, онцгой гавъяа, үйл бүтээсэн шадар зүтгэгсдэд шагнал болгож эзэмшүүлсэн нутаг, түүхч Д.Гонгор³³ “эзэн хаан ба түүний алтан ургийн өмч нутаг, түмэт, мянгатын буюу шууд хэлбэл засаг ноёдыг захирамж нутаг, талын язгууртнуудад дархалж олгосон нутаг байсан” гэж тус тус үзжээ. Өмч нутаг, харьяат нутаг, шагналын буюу дархалсан нутаг гэсэн хэлбэрүүд үүссэн нь *хожим төвлөрсөн засаг сулрахын хирээр дотоодын зөрчил тэмцэл гарах үндэс анхдагч шалтгаан болсон*. Их хаан зөрчил тэмцлийг зогсоон нэгэн захиргаанд багтаан, цэрэг дайчин тэр их хүчийг харь орныг эзлэх, ертөнц дахиныг төвшитгөхөд зангидаж өгснөөр, дотоодын зөрчлийг гадагш чиглүүлж байжээ.

Тэгвэл, XIV зууны II хагасаас хаант төр, гадаад дахь эзэмшлээ аажим аажмаар алдан, эдийн засгийн болон улс төрийн бүхий л үйл явц монгол нутагт өрнөх болсон. Энэ үед “харьяат иргэд бүгдээр албат” хэмээн нэрлэгдэх болж, хамжлагчлагдах ёсон бүрэн жигдрэн гүйцэлджээ. Улс орон эдийн засаг улстөрийн хувьд биеэ даасан олон тооны эзэмшлүүдэд хуваагдан³⁴ бутарчээ. XIV-XV зууны монголын нийгэмд мөлжлөгийн гол төв нь монголын өөрийн нийгэмд шилжин төвлөрөлтийн оронд улс төрийн бутрал болж ирсэнтэй холбоотой харь орны дарлан мөлжихөөс өөрийн орныг мөлжихөд шилжсэн тул мал аж ахуйн хөгжлийн шинэ үе болж мал аж ахуйн арга технологид дэвшил гарч хөдөлмөрийн бүтээмж өсөхөд хүргэсэн. Суурин “хот”, “хороо”, “байшин” гэх мэт шинэ хэлбэрүүд үүсч, худалдаа гар урлал, газар тариалан, шинэ шинэ алба татвар үүсч байв.

Н.Нацагдоржийн үзсэнчлэн феодализмын хөгжлийн явцад “том газрын өмч улам бэхжиж, феодалуудын эзэмшил өсч, эзний татвар нэмэгдсэн нь тухайн орны эдийн засгийн хөгжлийг ахиулах нөхцлийг бүрдүүлж...феодалын үйлдвэрлэлийн аргын хөгжилд зарим нэг дэвшил гардаг боловч улс төрийн хувьд бие даасан мужууд бий болох нь...улс төрийн амьдралд харш үзэгдлийг бий болгодог. Улс оронд биеэ даасан олон эзэмшлүүд бий болсноор хаад ноёдын өрсөлдөөн тэмцлийг нэмэгдүүлж”,³⁵ **хаан төрийн эрх хүч сулран, нэр хүнд доройтон** “энэ бүхэн нь гадаад байдлыг түгшүүртэй болгож, харийн булаан эзлэгчдийн эсрэг тэмцлийг”³⁶ сааруулж, үндэсний аюулгүй байдал, тусгаар тогтнолд аюул занал учруулах болсон нь дэлхийн бусад орны түүхэн үйл явцтай адил зүй

³² Ш.Нацагдорж. Монголын феодализмын үндсэн замнал. УБ., 1978, тал.58

³³ Д. Гонгор. Халх товчоон, II боть. УБ., 1978, тал. 246

³⁴ Ш.Нацагдорж. Монголын феодализмын үндсэн замнал. УБ., 1978, тал.137,

³⁵ Мөн тэнд, тал.31-35

³⁶ Ш.Нацагдорж. Монголын феодализмын үндсэн замнал. УБ., 1978, тал.135

тогтолт түүхэн үзэгдэл юм. Энэхүү өрсөлдөөн зөрчил тэмцлийн үндэс нь өмнөх үеэс уламжилсан хүн ард, мал сүрэг, хөрөнгө баялгийг газар нутагтай эзэмших туйлын хүсэл, хэмжээгүй их эрх мэдлийг төвлөрүүлэх явдал байсан.

“Хагарал бол ерөөсөө хоёр сөрөг хөдөлгөөний...шуналын үр дагавар, эрх баригч цөөнхи бүх эрхийг зөрчин уландаа гишгиж, ноёрхогч байдал, хуучин эрх ямба хадгалах гэж оролддог. Пролетари (эрх баригч цөөнхөөс бусад) нар шударга бус жигшүүрт явдлыг эсэргүүцдэг”³⁷ гэсэн ойлголттой дүйж байна. Дотоод зөрчил тэмцлийг хурцатгах гадаад хүчин зүйлс нь Монгол улсын хүчирхэг хөршүүд, Хятадын Мин улс, Манж чин улс, Хаант орос улсын гадаад бологотой шууд холбоотой.³⁸

Монгол дахь улс төрийн бутралын талаар Доктор М.Санждорж “Юань улс мөхснөөр түүнийг сэргээх гэсэн хүсэл мөрөөдөл, үр дүнгүй оролдлого, эрх булаалцалдсан хаад төр барьж улс төрийн бутралын үе эхэлжээ. Хааны эрх хүчин доройтон төрийн төвлөрсөн бодлого, төрийн засаглал, хууль цааз суларч, дотоодод хямрал дэгджээ. Усгал хаанаас хойш монголын дотоодод бүрэлдэж байсан бутрал зад тавьжээ...Мин улсын удаа дараагийн довтолгоон нь хаан ширээний хүчийг сулруулжээ. Нөгөө талаар Чингэсээс хойшхи 100 хол илүү жилийн дотор Алтан урагтан болон урьдын түмэт мянганы ноёд, дархан цолтны хойчис эзэн харьяатын ёсонд тулгуурлан нэгэнт бие даан толгой мэдэгчид болж байжээ. Монгол оронд нийгмийг нэгтгэн зангидах эдийн засгийн суурь үндэсгүй байсан болохоор тэр нэгдлийг хангаж байсан улс төрийн хүчин буюу хаант засгийн хүч сулрахаар төвөөс зугатаах хүчин илт давамгайлах болжээ. Энэ нь XIV зууны эцсээс Монгол улс төрийн бутралд автахын урьдчилсан үндэс болсон аж. Тэрхүү бутрал нь эзэн хааны захирах хүчин сулран доройтноос болов уу? Хувь эзэмшил бүхий ноёд язгууртан нарын эрх хүч ихэсснээс болов уу? Энэ нь нэгдмэл нэг үзэгдлийн хоёр тал...боловч, хувь эзэмшилт ноёд язгууртын хүчил анхдагч шинжтэй гол хүчин зүйл”³⁹ болно гэж Монгол дахь улс төрийн бутралын дотоод, гадаад шалтгаан түүхэн нөхцөл, цаг үеийг тодорхой дүгнэжээ. Мөн Доктор Л.Жамсран “Монгол ноёдын дотор засгийн эрх булаалцалдсан, харьяалан захирч байгаа нутаг, ард иргэдээ бүрэн эрхтэй захирахын төлөө өөр хоорондоо тэмцэлдэхийн зэрэгцээ бас ард олны дургүйцэл эсэргүүцэлтэй тулгарч байсан нь улс орныг гүнзгий хямралд оруулж, улмаар бутарч тарах үндсийг бий болгосон ажээ”⁴⁰ гэж тэмдэглэжээ.

Монгол төрийн өвөрмөц онцлог Их Монгол улс, Эзэнт гүрний үед Евроазид монголчуудын хүчирхэг нэгдлийг тогтоосон бол он улирахын хэрээр задрал бутралын үндсийг тавьжээ. Алтан урагтны “дархан эрх” нэгэн гэр бүл, удам угсаатны хэд хэдэн зэлгамжлагчдыг хаан ширээний төлөө өрсөлдөн тэмцэлдэхэд хүргэсэн. Орон нутгийн захирагч ноёдод итгэл “хүлээлгэн онцгой эрх” олгосон нь тэд хаанаасаа харьцангуй тусгаар бие даасан шинжтэй болж, хожим хаант засгийн төвлөрлийг сулруулж, ноёрхлыг хязгаарлахад хүргэсэн. Иймээс Монгол дахь засаглалын хямрал, улс төрийн амьдралын зөрчил, мөргөлдөөний уг үндэс нь улс орны түүхэн хөгжилтэй холбоотой нийгэм түүхийн үзэгдэл учраас дан ганц улс төрийн хүрээний асуудлаар тайлбарлах боломжгүй юм. Хүн төрөлхтөний болон монголын нийгэм түүхэн хөгжлийн өвөрмөц онцлогийн аль алийг нь харгалзан үзэх нь зайлшгүй болох нь дээр дурсан бүхнээс тодорхой харагдаж байна.

³⁷ А.Тойнби. Түүх судлал. УБ.,2007, тал.255

³⁸ Гадаад хүчин зүйлийн асуудлыг тусгайлан авч үзсэнгүй, хойшид томоохон судалгаа шаардлагатай гэж бодож байна

³⁹ М.Санждорж. Монгол төрийн түүхээс. УБ.,1998, тал.15,84

⁴⁰ Монголын төрийн байгуулал, улс төрийн сэтгэлгээний хөгжил (МЭӨ III-МЭ XX зуун) I боть. УБ.,1995, тал.73

Absract

On the issues of “Feudalism” and “Anti-Feudalism”

Annotation: In the reason that the issues related to political interrelations in Mongolian history of the Middle Age (medium ovum) – is strongly connected with the principles of “lord and serve”, the author gave her views of opinion on the problems of “feudalism”, “anti-feudalism” in the world history, and existence of feudalism in the history of Mongolia, also some problems ordinary and specific aspects of the nomadic society, in the article.

Номзүй

Гонгор.Д “Халх товчоон” II боть. УБ.,1978

Гомбосүрэн.Ц “Монголын уламжлалт нийгэм феодализм мөн үү” УБ.,1997

Ganshof, Francois-Lois, Feudalism. Tr. Philip Grierson. New York: Harper and Row, 1964

Ишжамц.Н “Монголд нэгдсэн төр улс байгуулагдаж феодализм бүрэлдэн тогтсон нь”
УБ.,1974

Крадин.Н “Эрнест Геллнер ба нүүдлийн феодализмын талаархи мэтгэлцээн”. Түүх.
сэтгүүл-III. УБ., 2004

Кэролин Хамфри. Дэвид Снит. “Нүүдэллэхүй ёсон эцэслэх үү?” УБ.,2006

Монголын хувь заяаны тулгамдсан асуудлууд. Цуврал I, УБ.,1997

Монголын төрийн байгуулал, улс төрийн сэтгэлгээний хөгжил (МЭӨ III-МЭ XX зуун) I
боть. УБ.,1995

Нацагдорж.Ш “ Монголын феодализмын үндсэн замнал” УБ.,1978

Санждорж.М “Монгол төрийн түүхээс” УБ.,1998

Тойнби.А. “Түүх судлал” УБ.,2007